



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 435

Улаанбаатар хот


“Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад”
улсад гаргах үнэт цаасыг мэдэгдэх тухай журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.3, 17.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг мэдэгдэх тухай журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Дээрх журам батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 83 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын үнэт цаасны зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 06 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 6.8 дахь хэсгийг хүчингүй болгосугай.
4. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



000477

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 13 тоот тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСАД БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД ГАДААД УЛСАД ГАРГАХ ҮНЭТ ЦААСЫГ МЭДЭГДЭХ ТУХАЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Монгол Улсад бүртгэгдсэн хуулийн этгээд /цаашид “мэдэгдэл гаргагч” гэх/ гадаад улсад үнэт цаас гаргах, арилжих тохиолдолд тухайн хуулийн этгээдийн үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-нд мэдэгдэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 17.1-д заасан хуулийн этгээд нь гадаад улсад үнэт цаас гаргах, арилжих тохиолдолд Хорооны 2014 оны 06 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ийн 6.6-д заасны дагуу Хороонд бүртгүүлнэ.

1.3. Энэхүү журмын 1.2-т зааснаас бусад Монгол Улсад бүртгэгдсэн хуулийн этгээд болон Засгийн газар, Аймаг, Нийслэлийн засаг дарга гадаад улсад гаргах үнэт цаасыг энэхүү журмын дагуу Хороонд мэдэгдэнэ.

Хоёр. Хороо мэдэгдлийг хүлээн авах, хариу өгөх

2.1. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас гаргах, арилжих, бүртгүүлэх тухай шийдвэрийг мэдэгдэл гаргагчийн эрх бүхий байгууллага Хороонд мэдэгдэнэ.

2.2. Энэхүү журмын 2.1-т заасан хуулийн этгээд нь Хороонд мэдэгдэхдээ дараах бичиг баримтыг хамт ирүүлнэ.

2.2.1. гадаад улсын зохицуулах байгууллага, Хөрөнгийн биржид гаргах үнэт цаасыг мэдэгдэх өргөдөл /энэ журмын нэгдүгээр хавсралт/ ;

2.2.2. гадаад улсад үнэт цаасыг гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;

2.2.3. улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

2.2.4. тухайн мэдэгдэл гаргагчийн үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй танилцуулга;

2.2.5. мэдэгдэл гаргагч нь банкны үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд бол энэ талаарх Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвшөөрөл;

2.2.6. мэдэгдэл гаргагч нь лиценз, тусгай зөвшөөрөл эзэмшигч бол холбогдох төрийн захиргааны байгууллагын лавлагаа;

2.2.7. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад.

2.3. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д заасан үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдэд энэхүү журмын 2.2.6 дахь заалт хамаарахгүй.

2.4. Мэдэгдэл гаргагч нь гадаад улсад үүсмэл үнэт цаас, өрийн хэрэгсэл гаргах, арилжих бол энэхүү журмын 2.2-д зааснаас гадна дараах бичиг баримтыг Хороонд хүргүүлнэ.

2.4.1. үнэт цаас гаргагчийн танилцуулга;

2.4.2. үнэт цаасны танилцуулга /энэ журмын хоёрдугаар хавсралт/.

2.5. Хороо энэхүү журмын 2.2, 2.4-д заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор Хорооны дарга хариу өгнө.

2.6. Хороо ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу бол мэдэгдэл гаргагчаас нэмэлт мэдээлэл, баримт бичиг, тайлбар гаргуулан авах, тэдгээрийг холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажуулахыг шаардаж болно.

2.7. Хорооны дарга шаардлагатай гэж үзэн Хорооны хуралд хэлэлцүүлэхээр шийдвэрлэвэл энэ тухай мэдэгдэл гаргагчид мэдэгдэн Хорооны хурлаар шийдвэрлэгдэхээс өмнө тайлбар гаргах боломж, нөхцлөөр хангаж болно.

2.8. Хороо мэдэгдэл гаргагчийн гадаад улсад үнэт цаас гаргах, арилжих, бүртгүүлэх тухай мэдэгдлийг хүлээн авч дэлгэрэнгүй бүртгэл хөтөлиө.

2.9. Мэдэгдэл гаргагч нь гадаадын холбогдох хууль тогтоомжийн дагуу Гадаадын зохицуулах байгууллага, хөрөнгийн биржид үнэт цаасыг бүртгүүлж үнэт цаасыг арилжаалснаас хойш ажлын 5 хоногийн дотор Хороонд үнэт цаас арилжсан тайланг ирүүлнэ. /энэ журмын гуравдугаар хавсралт/

2.10. Мэдэгдэл гаргагч нь гадаад улсад үнэт цаас гаргах тухай мэдэгдэл, түүний танилцуулгыг Хороонд мэдэгдэл хүргүүлсэнээс хойш зургаан сарын дотор гадаадын зохицуулах байгууллага, хөрөнгийн биржид бүртгүүлэн нийтэд танилцуулах бөгөөд уг хугацаа дууссан өдрөөс хойш тухайн үнэт цаасыг дахин нийтэд санал болгох бол тус Хороонд анх мэдэгдсэний дагуу дахин мэдэгдэл хүргүүлнэ.

Гурав. Мэдээлэл солилцох

3.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.17, 64.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хороо нь Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага(IOSCO) болон санамж бичиг, гэрээ байгуулсан гадаад улсын зохицуулах байгууллага болон хөрөнгийн биржид мэдээлэл хүргүүлж болно.

3.2. Дараах тохиолдолд Хорооноос Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага болон санамж бичиг, гэрээ байгуулсан гадаад улсын зохицуулах байгууллага болон хөрөнгийн биржид мэдээлнэ.

- 3.2.1. хүсэлтийг энэхүү журмын дагуу гаргаагүй;
- 3.2.2. шаардлагатай мэдээллийг хүсэлтэд тусгаагүй, эсхүл дутуу тусгасан;
- 3.2.3. худал, төөрөгдүүлсэн, алдаатай, эсхүл хоорондоо зөрүүтэй мэдээлэл тусгасан;
- 3.2.4. энэхүү журмын 3.2.1-д заасан мэдээлэлд үндэслэн үнэт цаасыг нийтэд танилцуулсан болох нь тогтоогдсон.

Дөрөв. Хариуцлага

- 4.1. Энэхүү журмыг зөрчсөн хуулийн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан захиргааны хариуцлага ногдуулна.

ооОоо

Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад
улсад гаргах үнэт цаасыг мэдэгдэх тухай журмын
нэгдүгээр хавсралт

**ХОРООНД МОНГОЛ УЛСАД БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД ГАДААД
УЛСАД ГАРГАХ ҮНЭТ ЦААСЫГ МЭДЭГДЭХ ТУХАЙ ӨРГӨДӨЛ**

Огноо:/..../....

Он, сар, өдөр

Санхүүгийн зохицуулах хороонд

1. Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

1.1. Оноосон нэр:

1.3. Регистрийн дугаар:

1.4. Үйл ажиллагааны чиглэл:

1.6. Оршин байх албан ёсны хаяг

/Гадаад Улсад төлөөлөгчийн
газартай бол түүний хаягийг мөн
бичнэ/:

1.7. Шуудангийн болон цахим шуудангийн
хаяг, холбоо барих утас:

Санхүүгийн зохицуулах хорооны гадаад улсын үнэт цаасны зах зээлд дараах үнэт цаасыг гаргахаар энэхүү өргөдлийг гаргаж байна. Монгол улсад бүртгэгдсэн хуулийн этгээд гадаавын үнэт цаасны зах зээлд үнэт цаасаа гаргах тухай журамд заасан холбогдох ... нүүр баримт бичгийг хавсарган хүргүүлэв.

2. Үнэт цаасны мэдээлэл

2.1. *Үнэт цаасны нэр:*

2.2. *Өмнө аль нэгэн гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй эсэх болон үнэт цаас гаргасан улс, бүртгэлтэй хөрөнгийн бирж:*

2.3. *Өмнө аль нэгэн гадаад улсад үнэт цаас гаргасан бол түүнийг зөвшөөрсөн эрх бухий байгууллага болон бүртгэсэн хөрөнгийн биржийн шийдвэрийн дугаар, огноо:*

2.4. *Өмнө гадаад улсад үнэт цаас гаргасан бол үнэт цаасны төрөл, нэрлэсэн үнэ, тоо ширхэг, код, ISIN код:*

2.5. *Анх удаа эсхүл ичмэж гаргах үнэт цаасны төрөл:*

2.6. Үнэт цаас гаргах хөрөнгийн биржс:

2.7. Тoo ширхэг:

2.8. Нэрлэсэн үнэ:

2.9. Хугацаа, хүү

2.11. Үнэт цаас гаргах замаар нийтээс татан төвлөрүүлэхээр тооцсон хөрөнгийн хэмжээ:

2.12. Үнэт цаасны нөхцөл /хямдруулсан, хөвөх, тогтмол хүүтэй, хугацаанаас нь өмнө эргүүлэн татах г.м./:

2.13. Үнэт цаасыг нийтэд санал болгон арилжихаар толөвлөсөн хугацаа:

2.14. Үнэт цаас гаргах замаар олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн зориулалтын талаарх товч мэдээлэл:

3. Үнэт цаас гаргагчид мэргэжлийн зөвлөгөө өгсөн зохицуулалттай хуулийн этгээдийн мэдээлэл

3.1.1. *Андеррайтерийн оноосон нэр*

/синдикат хэлбэрээр оролцож байгаа
бол энэ болон дараах мэдээллийг мөн
бичнэ:/

3.1.2. *Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн
дугаар:*

3.1.3. *Регистрийн дугаар:*

3.1.4. *Эрх бүхий байгууллагаас олгосон
энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай
зөвшөөрлийн дугаар, огноо:*

3.1.5. *Оршин байх албан ёсны хаяг /Монгол
Улсад төлөөлөгчийн газартай бол
түүний хаягийг мөн бичнэ:/*

3.1.6. *Шуудангийн болон цахим шуудангийн
хаяг, холбоо барих утас:*

3.2.1. Хуулийн зөвлөгөө өгсөн компанийн
оноосон нэр:

3.2.2. Бүртгэлтэй улс, бүртгэлийн дугаар:

3.2.3. Регистрийн дугаар:


3.2.4. Эрх бүхий байгууллагаас олгосон
энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай
зөвшөөрлийн дугаар, огноо:

3.2.5. Оршин байх албан ёсны хаяг

/Гадаад Улсад төлөөлөгчийн
газартай бол түүний хаягийг мөн
бичнэ/:

3.2.6. Шуудангийн болон цахим шуудангийн
хаяг, холбоо барих утас:

3.3. Үнэт цаас гаргагч нь энэхүү үнэт цаас гаргахтай холбоотойгоор ямар нэгэн
хөндлөнгийн шинжээч, мэргэжилтэнтэй гэрээ байгуулан ажилласан болон энэ тухай
мэдээлэл:



Энэхүү өргөдөл, түүнд хавсарган хүргүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг өргөдөл гаргагч билд бүрэн хариуцах бөгөөд хөрөнгө оруулагчид тохиолдоож болзошгүй эрсдэл, хөрөнгө оруулагчдад хүргэвэл зохих мэдээллийг үнэт цаасны таницуулгад үнэн зөв, бүрэн тусгасан болно.

Өргөдөл гаргасан:

1. Овог, нэр: 4. Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч

“.....” –....К-ийн ТУЗ-ийн дарга

Гарын үсэг:

Албан тушаал:

андеррайтерийн компанийн ТУЗ-ийн
дарга

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

2. Овог, нэр:

5. Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч

“.....” –....К-ийн гүйцэтгэх
захирал

Гарын үсэг:

Албан тушаал:

.....андеррайтерийн компанийн
гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

3. Овог, нэр:

6. Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч

“.....” –....К-ийн Ерөнхий
нягтлан бодогч

Гарын үсэг:

Албан тушаал: хуулийн

зөвлөх “.....” –ХХК-ийн
гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

Өргөдөл гаргасан огноо:


Өргөдөлтэй холбоотой асуудлыг
хариуцан ажиллах ажилтны овог нэр,
албан тушаал, холбоо барих утас:

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооны ажилтан бөглөно/

Өргөдөл хүлээн авсан ажилтаны овог нэр:	Өргөдөл хүлээн авсан огноо, цаг, минут:	Өргөдөл түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:
--	--	--

Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад
улсад гаргах үнэт цаасыг мэдэгдэх тухай журмын
хоёрдугаар хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА



Огноо:/..../....

On, cap, өдөр

Санхүүгийн зохицуулах хороонд

**1. Өрийн хэрэгсэл гаргагчийн
өрөнхий мэдээлэл**

1.1. Оноосон нэр:

1.2. Өмнө аль нэгэн гадаад улсын
хөрөнгийн бирж дээр өрийн хэрэгсэл
гаргаж байсан бол бүртгэлтэй
бирж, листингийн төрөл:

1.3. Оршин байх албан ёсны хаяг

/ Гадаад Улсад төлөөлөгчийн
газартай бол түүний хаягийг мөн
бичнэ /:

1.4. Шуудангийн болон цахим шуудангийн
хаяг, холбоо барих утас:

2. Θрийн хэрэгслийн талаарх мэдээлэл

- 2.1. Үнэт цаас гаргагчийн өрийн хэрэгслийг бүртгэх эрх бүхий байгууллагын нэр:

- 2.2. Θрийн хэрэгсэл гаргах валютын нэр, гаргах хэлбэр:

- 2.3. Гаргах өрийн хэрэгслийн хувь хэмжээ, тоо ширхэг:

- 2.4. Гаргах орийн хэрэгслийн нэрлэсэн үнэ /дээд, доод, дундааж ханш/:

- 2.5. Эргэлтэнд байх болон байршиулах хугацаа, гадаад улсын үнэт цаасны зах зээлд байршиулах үнс тогтоосон нөхцөл/:

- 2.6. Θрийн хэрэгслийн төрөл /купонтой, хямдруулсан, баталгаатай болон баталгаагүй эсэх/:

- 2.7. Баталгаатай өрийн хэрэгсэл гаргаж буй нөхцөлд баталгааг дурдана /Үнэт цаас гаргагчийн хөрөнгөөр барьцаа болгон хариуцлага хүлээх болон гуравдагч этгээд баталгаа гаргаж байгаа эсэх/:

- 2.8. Өрийн хэрэгслийн хүү тооцох болон олгох тухай журам, өрийн бичиг эзэмшигчдэд олгох хүүгийн хэмжээ, хүү төлөх үечлэл:

- 2.9. Өрийн хэрэгсэл гаргах замаар олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн зориулалтын талаарх төвч мэдээлэл:

Тайлан гаргасан:

1. Овог, нэр:.....

2. Овог,
нэр:.....

Албан тушаал: Өрийн хэрэгсэл гаргагч
“.....” –ХК-ийн ТУЗ-ийн дарга

Албан тушаал: Өрийн хэрэгсэл гаргагч
“.....” –ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:.....

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

Монгол Улсад бүртгэлтэй хуудийн этгээд гадаад
улсад гаргах үнэт цаасыг мэдэгдэх тухай журмын
гуравдугаар хавсралт

**МОНГОЛ УЛСАД БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД ГАДААД УЛСЫН ҮНЭТ
ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД НИЙТЭД САНАЛ БОЛГОН
ҮНЭТ ЦААС АРИЛЖСАН ТУХАЙ ТАЙЛАН**

Огноо:/..../....

On, cap, өдөр

Санхүүгийн зохицуулах хороонд

1. Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

1.1. Оноосон нэр:

1.2. Гаргасан үнэт цаасны нэр, төрөл,
тоо ширхэг, нэрлэсэн үнэ, хугацаа,
хүү, код, ISIN код:

1.3. Оршин байх албан ёсны хаяг

/ Гадаад Улсад төлөөлөгчийн
газартай бол түүний хаягийг мөн
бичнэ /:

1.4. Шуудангийн болон цахим шуудангийн
хаяг, холбоо барих утас:

1.5. Үнэт цаас гаргахыг зөвшиөөрсөн эрх
бүхий зохицуулагч байгууллагын

шийдвэрийн огноо, дугаар:

- 1.6. *Анхдагч зах зээлд арилжаалж эхэлсэн болон дууссан огноо:*

2. Анхдагч зах зээлийн арилжааны мэдээлэл

- 2.1. *Андеррайтерийн оноосон нэр /синдикат хэлбэрээр оролцсон бол оролцогч талын мэдээллийг мөн бичнэ/:*

- 2.2. *Анхдагч зах зээлийн арилжааг явуулсан хөрөнгийн бирж:*

- 2.3. *Нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны хувь хэмжээ, тоо ширхэг:*

- 2.4.1. *Нийтэд санал болгон арилжсан нэгж хувьцааны үнэ /дээд, доод, дундаж хани/:*

- 2.4.2. *Үнэт цаасыг хаалттай захиалгын хүрээнд санал болгон худалдсан бол нэгж хувьцааны үнэ болон хаалттай хүрээнд санал болгон арилжсан тоо, хувь /энэ хэсэгт үнэт цаасыг тэргүүн ээлжиснд худалдан авсан хувьцаа эзэмшигчийн мэдээлэл мөн хамаарна/:*

- 2.4.3. *Ажиллагсдад хувьцаа өзэмшигүүлэх хөтөлбөр /ESOP/ хэрэгжүүлсэн бол нэгж хувьцааг тооцсон үнэ, тэдгээрт эзэмшигүүлсэн хэмжээ:*

2.4.4. Өрийг хувьцаагаар сольсон бол хувьцаанд хөрвүүлсэн өрийн хэмжээ, нэгж хувьцааг тооцсон үнэ, хөрвүүлсэн хувьцааны тоо:

2.5. Татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн хөрөнгийн хэмжээ:

2.6. Нийтэд арилжигдсан үнэт цаасны тоо, татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ:

2.7. Татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө нь үнэт цаасны танилцуулгад заасан зориулалтаар зарцуулахад хүрэлцээтэй эсэх:

 ТИЙМ УГҮЙ*

*УГҮЙ хариултыг сонгосон бол холбогдох тайлбрыг бичнэ.

2.8.1. Нийтэд санал болгон арилжссан үнэт цаасны төлбөр үнэт цаас гаргагчийн зохих дансанд бүрэн байршсан эсэх:

2.8.2. Өрийг хувьцаагаар сольсон бол зээлдүүлэгчийн дансанд түүний хөрөүүлийн эзэмшил хувьцаа бүрэн байршсан эсэх:

2.9. Нийтэд санал болгон анхдагч зах зээлд арилжссан үнэт цаасны 5 болон түүнээс дээш хувийг дангаар

эсхүл нэгдмэл сонирхолтой
этгээдтэй хамтран худалдан авсан
этгээдийн эзэмшиж буй үнэт
цаасны тоо, хувь:

- 2.10. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаатай холбоотой нэмэлт тайлбар, мэдээлэл
болон уг арилжаатай холбогдох санал, гомдол байгаа эсэх:

Тайлан гаргасан:

2. Овог, нэр: 3. Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
“.....” -ХК-ийн ТУЗ-ийн дарга

Албан тушаал:
андеррайтерийн компанийн ТУЗ-ийн
дарга

Гарын үсэг:

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

3. Овог, нэр: 4. Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
“.....” -ХК-ийн гүйцэтгэх
захирал

Албан тушаал:
.....андеррайтерийн
компанийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)